

Хэрэглэгчдэд зориулсан эм хэрэглэх заавар

**Ремантадин 50мг шахмал (Remantadin 50 mg Tablets)**

Римантадины гидрохлорид

**Бэлдмэлийг хэрэглэхийн өмнө уг эм хэрэглэх зааврыг анхааралтай уншина уу. Учир нь танд хэрэгтэй чухал мэдээлэл агуулна.**

Уг бэлдмэлийг жоргүй олгодог учир эмчилгээний сайн үр дүн үзүүлэхийн тулд түүнийг болгоомжтой хэрэглэх хэрэгтэй.

- Уг эм хэрэглэх зааврыг хадгалаарай. Учир нь түүнийг дахин унших шаардлага гарч болно.
- Хэрэв танд нэмэлт мэдээлэл шаардлагатай болвол эм зүйчээс асуугаарай.
- Хэрэв танд ямар нэгэн гаж нөлөө илэрвэл эмчлэгч эмч болон эм зүйчдээ мэдэгдээрэй. Үүнд уг эм хэрэглэх зааварт тэмдэглэгдээгүй илэрч болох гаж нөлөө хамаарна. 4-р хэсгийг үз.
- Хэрэв З хоногийн эмчилгээний дараа таны биеийн байдал сайжрахгүй буюу эсвэл дордвол эмчлэгч эмчдээ хандаарай.

**Уг эм хэрэглэх зааварт:**

1. Ремантадин гэж юу вэ? Түүнийг юунд хэрэглэдэг вэ?
2. Ремантадин бэлдмэлийг хэрэглэхийн өмнө та юу анхаарах вэ?
3. Ремантадин бэлдмэлийг яаж хэрэглэх вэ?
4. Илэрч болох гаж нөлөө
5. Ремантадин бэлдмэлийг хэрхэн хадгалах вэ?
6. Савлалтын агууламж болон бусад мэдээлэл

**1. Ремантадин гэж юу вэ? Түүнийг юунд хэрэглэдэг вэ?**

Бэлдмэл римантадины гидрохлорид (уг эм хэрэглэх зааварт римантадин гэж нэрлэсэн) агуулдаг бөгөөд энэ нь вирусын эсрэг эмийн бүлэгт хамаарна. Бэлдмэл томуугийн А вирус болон бусад А бүлгийн вирусын эсрэг, түүнчлэн томуугийн В вирусээр үүсгэгдсэн хордлогын үед хортой нөлөөний эсрэг үйлдэл үзүүлнэ.

Бэлдмэл хачигт энцефалит үүсгэдэг flavivirusesын эсрэг үр дүнтэй нөлөөлнө.

Ремантадиныг насанд хүрэгсэд ба 7-с дээш насны хүүхдийн томуугийн эрт үеийн эмчилгээ болон насанд хүрэгсэд ба 7-с дээш насны хүүхдийн томуугийн дэгдэлтийн үеийн томуугийн вирусээр үүсгэгдсэн өвчинөөс сэргийлэх, насанд хүрэгсдэд хачигт энцефалитаас сэргийлэх зорилгоор тус тус хэрэглэнэ.

**2. Ремантадин бэлдмэлийг хэрэглэхийн өмнө та юу анхаарах вэ?**

Дараах тохиолдолд бэлдмэлийг хэрэглэхгүй.

- Римантадин, адамантаны бүлгийн бэлдмэл болон бэлдмэлийн найрлага дахь бусад туслах бодист хэт мэдрэг хүмүүс (6-р хэсэгт жагсаасан)
- Цочмог явцтай элэгний өвчин
- Цочмог ба архаг явцтай бөөрний өвчин
- Тиреотоксикоз (бамбай булчирхайн хэт идэвхжил)

- Жирэмсэн ба хөхүүл үе

**Анхааруулга ба болгоомжлол!**

Бэлдмэлийг хэрэглэхийн өмнө эмчлэгч эмчтэйгээ зөвлөнө.

- Хоол боловсруулах замын эмгэг
- Элзгний үйл ажиллагааны өөрчлөлт
- Хүнд явцтай зүрхний эмгэг буюу зурхний хэмнэл алдагдал
- Настангууд

Эдгээр тохиолдолд ремантадины тунг багасгана.

Хэрэв та эпилепситэй болон ремантадинтай хамт таталдааны эсрэг эм хэрэглэж байгаа бол эпилепсийн уналт үүсэх эрсдэл нэмэгдэнэ. Энэ тохиолдолд бэлдмэлийн хоногийн тунг 100мг болгон бууруулна. Эпилепсийн уналт илэрсэн тохиолдолд ремантадиныг зогсоноо.

**Эмийн харилцан үйлчлэл:**

Хэрэв та ямар нэгэн эмийн бэлдмэл хэрэглэж дуусаад удаагүй болон хэрэглэж байгаа, эсвэл хэрэглэх гэж байгаа бол эмчлэгч эмч буюу эм зүйчдээ мэдэгдээрэй.

Парацетамол болон ацетилсалицилын хүчил нь ремантадины үйлдлийг сулруулна.

Циметидин бэлдмэлийн үйлдлийг хүчжүүлнэ.

**Ремантадиныг хоол хүнс, ундаа, согтууруулах ундаатай хамт хэрэглэх нь:**

Хоол хүнсний зүйл нь бэлдмэлийн шимэгдэлтэнд нөлөөлөхгүй. Согтууруулах ундаа хэрэглэхээс зайлсхийнэ. Учир нь ТМС-ийн зүгээс гаж нөлөө илэрч болно.

**Жирэмсэн ба хөхүүл үе, нөхөн үржих чадвар:**

Бэлдмэлийг хэрэглэхгүй.

**Жолоо барих болон машин механизмтай ажиллах чадварт бэлдмэлийн үзүүлэх нөлөө:**

Бэлдмэлийг хэрэглэх үед толгой эргэх, толгой өвдөх зэрэг ТМС-ийн зүгээс гаж нөлөө илэрвэл болгоомжилно.

**Ремантадины найрлагад лактоз агуулагддаг.**

Ремантадины шахмалд 74,5мг лактозын моногидрат агуулагддаг. Хэрэв эмч танд зарим төрлийн сахар зохидоггүй гэж хэлсэн бол бэлдмэлийг хэрэглэхээс өмнө эмчлэгч эмчтэйгээ зөвлөнө.

**3. Ремантадин бэлдмэлийг яж хэрэглэх вэ?**

Бэлдмэлийг уг эм хэрэглэх заавар болон эмчлэгч эмч, эм зүйчийн зааврыг нарийн баримтлан хэрэглэнэ. Хэрэв танд ойлгомжгүй зүйл байвал эмч болон эм зүйчтэйгээ шалгаарай.

Шахмалыг шингэнээр даруулж хоолны дараа ууж хэрэглэнэ.

Ремантадины эмчилгээг томуугийн шинж эхэлж илэрсний дараа аль болох түргэн эхэлнэ.

Бэлдмэлийг эхний 48 цагийн дотор хэрэглэвэл эмчилгээний илэрхий үр нөлөө илэрнэ.

#### **Томуугийн эмчилгээ:**

Насанд хүрэгсэд: Эхний өдөр 100мг тунгаар (2 шахмал) хоногт 3 удаа, 2 ба 3 дахь өдөр 100мг-р хоногт 2 удаа, 4 ба 5 дахь өдөр 100мг-р хоногт 1 удаа тус тус хэрэглэнэ. Өвчний эхний өдөр 150мг-р (3 шахмал) 2 удаа, эсвэл 300мг-р (6 шахмал) 1 удаа хэрэглэж болно.

#### **Хүүхэд болон өсвөр насыхны хэрэглээ:**

Ремантадиныг хүүхдэд хэрэглэхийн өмнө зайлшгүй эмчид хандаж зөвлөгөө авна.

7-10 насын хүүхдэд 50мг (1 шахмал)-р хоногт 2 удаа, 11-14 насын хүүхдэд 50мг (1 шахмал)-р хоногт 3 удаа, 14-с дээш насын хүүхдэд насанд хүрэгсдийн тунгаар тус тус хэрэглэнэ.

Ээлж эмчилгээ 5 өдөр үргэлжилнэ.

#### **Томуугаас сэргийлэх:**

Насанд хүрэгсдэд: 50мг (1 шахмал)-р хоногт 1 удаа, 30 өдөр хүртэл хугацаагаар хэрэглэнэ.

#### **Хүүхэд болон өсвөр насыхны хэрэглээ:**

7-оос дээш насын хүүхдэд 50мг-р хоногт 1 удаа 15 хүртэл өдөр хэрэглэнэ.

#### **Хачигт хазуулсны дараа хачигт энцефалит үүсэхээс сэргийлэх:**

Насанд хүрэгсэд: 100мг (2 шахмал)-р хоногт 2 удаа 3 өдөр, хүнд тохиолдолд (эмчийн заалтаар) 5 өдөр хэрэглэнэ.

Ремантадиныг урьдчилан сэргийлэх зорилгоор хачигт хазуулсны дараа шууд (48 цагийн дотор) эхэлж хэрэглэнэ.

#### **Хачигт хазуулаагүй үед хачигт энцефалит үүсэхээс сэргийлэх:**

Зарим тохиолдолд зөвхөн насанд хүрэгсдэд (эрсдэл бүлэг, их өвс ногоотой хөдөө болон ойд явганаар аялж буй хүмүүс, майханд амьдарч буй хүмүүс) урьдчилан сэргийлэх зорилгоор 50мг-р хоногт 2 удаа 15 өдөр хүртэл хугацаагаар хэрэглэнэ.

#### **Тун хэтэрсний улмаас илрэх нөлөө:**

Хэрэв та эмчийн зөвлөсөн тунг хэтрүүлж хэрэглэсэн тохиолдолд яаралтай эмч дуудна.

#### **Хэрэв та бэлдмэлийг хэрэглэлгүй мартаж өнгөрөөсөн бол:**

Бэлдмэлийг хэрэглэх цагтаа хэрэглэлгүй мартаж өнгөрөөсөн бол санасан даруйдаа аль болох түргэн хэрэглэх ба цаашид эмчилгээг ердийнөөр үргэлжлүүлнэ.

Мартсан тунг нөхөхийн тулд тунг давхарлаж хэрэглэж болохгүй.

#### 4. Илэрч болох гаж нөлөө

Бэлдмэлийг хэрэглэх үед бусад эмийн бэлдмэлийн нэгэн адилаар гаж нөлөө ажиглагдах боловч энэ нь бүх хүмүүст илэрдэггүй.

Олонтаа илрэх (10 өвчтөнд 1-с цөөн): нойргүйдэх, дотор муухайрах, бөөлжих

Хааяа илрэх (100 өвчтөнд 1-с цөөн): зүрх дэлсэх, зүрхний дутагдал, зүрхний хориг, зүрхний цохилт олшрох, толгой эргэх, толгой өвдөх, түгшүүрэл ихсэх, сульдах, анхаарал төвлөрүүлэлт өөрчлөгдөх, хөдөлгөөний зохицуулга алдагдах, нойрмоглох, сэтгэл унал, сэтгэл хөөрөл, өөрийн мэдэлгүй хөдлөх, салганах, хий үзэгдэл, ухаан балартах, таталдаа, үнэрлэх мэдрэхүй багасах буюу алдагдах, чих шуугих, хоолонд дургүй болох, ам хатах, ходоод өвдөх, суулгах, хоол боловсруулах замын эмгэг, тууралт, цусны даралт ихсэх, тархины цусны эргэлтийн өөрчлөлт, муужрах, сульдах

Гаж нөлөөний давтамж (ялангуяа хоол боловсруулах замын болон мэдрэлийн системийн) бэлдмэлийн зөвлөсөн тунг хэтрүүлж хэрэглэх үед ихсэнэ.

Тунг хэтрүүлж хэрэглэсэн зарим тохиолдолд нулимс ихээр ялгарах, олон дахин шээх, халуурах, өтгөн хатах, ихээр хөлрөх, амны хөндийн үрэвсэл, мэдрэг чанар ихсэх, нүд өвдөх зэрэг шинж ажиглагдана.

Ихэнх гаж нөлөө бэлдмэлийг хэрэглэхээ зогсоох үед арилна.

Хэрэв танд гаж нөлөө хүнд явцтай илрэх буюу эсвэл уг эм хэрэглэх зааварт тэмдэглэгдээгүй ямар нэгэн гаж нөлөө илэрвэл эмчдээ мэдэгдээрэй.

#### 5. Ремантадин бэлдмэлийг хэрхэн хадгалах вэ?

25°C-аас доош хэмд хадгална. Гэрэл ба чийгнээс хамгаалах зорилгоор үйлдвэрийн савлагаанд нь хадгална.

Бэлдмэлийг хүүхэд үзэж хүрэхээргүй газар хадгална.

Савлалтан дээрх хүчинтэй хугацаа дууссанаас хойш бэлдмэлийг хэрэглэхгүй. Хүчинтэй хугацаанд тухайн сарын сүүлийн өдөр хамаарна.

Ямар нэгэн бэлдмэлийг гэрийн бохирын ус болон ахуйн хогонд хаяж устгаж болохгүй. Цаашид хэрэглэгдэхгүй болсон бэлдмэлийг хэрхэн устгах талаар эмч зүйчээсээ асуугаарай. Энэ нь хүрээлэн буй орчноо хамгаалахад тусална.

#### 6. Савлалтын агууламж болон бусад мэдээлэл

##### Найрлага:

Үйлчлэгч бодис: римантадины гидрохлорид

1 шахмалд 50мг римантадтины гидрохлорид агуулагдана.

Туслах бодис: лактозын моногидрат 74,5мг, төмсний цардуул, стеарины хүчил

##### Ремантадины дүрслэл болон савлалт:

Цагаан буюу цагаавтар өнгөтэй, дугуй хэлбэртэй, налуу ирмэг бүхий хавтгай шахмал.

Шахмалыг 10 ширхгээр блистертэй гаргах бөгөөд 2 блистерийг (20 шахмал) эм хэрэглэх зааврын хамт цаасан хайрцганд савлаж гаргана.

##### Үйлдвэрлэгч болон лиценз эзэмшигч:

Компаний нэр: Joint-Stock Company OLAINFARM